

Монголын тэргэнцэртэй иргэдийг дэмжих “Төмөр” сангаас хэрэгжүүлж буй
Мониторингийн төслийн товч танилцуулга.

ТӨСЛИЙН НЭР:

“БИДНИЙ ЭРХ ЗӨРЧИГДӨӨД БАЙНА”

Зорчих бэрхшээлтэй иргэдийн “Хөл орлох унаа”
болох гар удирдлагатай автомашиныг ашиглах эрх зүйн
орчинг боловсронгуй болгох нь

ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Зорчих бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдийн “Хөл
орлох унаа” болох гар удирдлагатай автомашиныг эзэмших,
ашиглахад учирч байгаа хүндрэл бэрхшээл, энэ талаархи
Монгол Улсын хууль, тогтоомж, түүнийг хэрэгжүүлэгч төрийн
байгууллага, албан тушаалтаны үйл ажиллагаанд үнэлэлт
өгч, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгоход хувь
нэмэр оруулна.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Улаанбаатар хотын хэмжээнд.

ОДООГООР ХИЙГДСЭН АЖИЛ:

- Төлөвлөгөөний дагуу холбогдох хууль, тогтоомжийг судласан.
- Зорчих бэрхшээлтэй жолооч нар, тэдний эзэмшилд байгаа өвтомашин
судалгаа гаргасан
- Япон, Солонгос, Хятад орнуудын туршлагыг судлаж байна.
- Манай сангийн ажил төрлийн байдалтай танилцахаар ирсэн Япон улсын
“JAPANESE SOCIETY FOR RENABILITATION OF PERSONS WITH
DISABILITES”, “INTERNGTIONAL TRAINING SECTION PLANNING AND
TRANING DIVISION”, “THE DUSKIN AINOWA FOUNDATION”
Байгууллагуудын төлөөлөгчдөд мониторингийн төслийн танилцуулга, явцын
талаар мэдээлж, тухайн орны энэ талын туршлага, үйл ажиллагааны
талаарх мэдээлэл авсан.
- Монгол дахь Хятад Улсын элчин сайдын Яамтай хамтран ажиллах явцдаа
тухайн орны энэ талын ажиллагааны талаархи мэдээлэл авч, манайтай
адил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын туршлагын талаарх
мэдээлэлийг харилцан солилцох боломж олгохыг Элчин Сайд ГОУ ШИ МАО
амлалаа.
- Нийслэлийн зам тээврийн газар, Хотын нийтийн тээврийн үйлчилгээний
газар, Замын цагдаагийн газар, Авто прожект байгууллага, Мастер плаза
зэрэг байгууллагуудад албан тоот явуулж мэргэжлийн байгууллагуудын
ажилтадаас ярилцлага авлаа.
- Зорчих бэрхшээлтэй жолоочтой автомашины тусгай зогсоолын үзлэг
хийсэн.
- Зорчих бэрхшээлтэй жолооч нартай фокус ярилцлага хийж, судалгаа авсан
- Зохих хуулиудад өөрчлөлт шинэчлэлт оруулах талаарх саналаа Монгол
Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяраар уламжлан УИХ-д өргөн бариад хаврын
чуулганаар хэлэлцэх төлөвлөгөөнд оруулж батлуулсан.
- Телевизийн “Тулга –5” студид холбогдох видео бичлэгийн зураг авалт
хийгдэж байгаа.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Хүмүүн заяа” сонинд мониторингийн
талаарх мэдээлэл өгсөн.
- Цугларсан мэдээ, материалаа нэгтгэн төвлөрүүлж олон нийтэд мэдээлэхээр
бэлтгэж байна.

Фокус ярилцлагад оролцсон тэргэнцэртэй иргэдэд олгосон унааны зардал

дд	Овог нэр		Олгосон ₮	Гарын үсэг
1				
2				
3				
4				
5				
6				

Фокус ярилцлагад оролцсон тэргэнцэртэй иргэдэд олгосон унааны зардал

дд	Овог нэр		Олгосон ₮	Гарын үсэг
1				
2				
3				
4				
5				
6				

Фокус ярилцлагад оролцсон тэргэнцэртэй иргэдэд олгосон унааны зардал

дд	Овог нэр		Олгосон ₮	Гарын үсэг
1				
2				
3				

4				
5				
6				

Мэргэжлийн байгууллагуудын ажилтантай хийх ярилцлагын төлөвлөгөө

Огноо: 2007 оны.....сарынөдөр.

Ярилцлага явуулсан газар.....

Хариулагчын овог.....нэр.....

Албан тушаал

Эхлэсэн цаг.....минут.....

Дууссан цаг.....минут.....

-Таны ажилд зорчих бэрхшээлтэй, ялангуяа тэргэнцэртэй иргэдийн асуудал хөндөгдсөн зүйл байдэг уу

- Байдаг бол энэ талаар таны бодол
- Танайд энэ чиглэлээр зарцуулах төсөв байдаг уу?

-Тэргэнцэртэй иргэд ямар асуудлыг танайд тавьж, шийдвэрлүүлж болох вэ?

- Зорчих бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэд танайхаар үйлчлүүлдэг үү?

-Тэднээс ямар нэгэн санал хүсэлт, гомдол ирж байсан уу?

-Ирсэн бол хэрхэн барагдуулсан бэ?

- Тэргэнцэртэй иргэд гадуур явхад хүндрэлтэй байдаг, энд ямар өөрчлөлт хийх хэрэгтэй гэж та боддог вэ?
- Тэргэнцэртэй иргэд таксинаас бусад нийтийн тээврээр хот дотор үнэгүй үйлчлүүлэх үнэмлэх авах эрхтэй гэвч тэр үнэмлэхийг авлаа ч ашиглах боломжгүй тул хохирдог. Энэ асуудлыг Таны бодлоор яаж зохицуулавал дээр вэ?
- Урьд нь Гар удирдлагатай автомашиныг төрөөс нэгдсэн журмаар захиалан авчирч, хөнгөлттэй нөхцөлөөр олгодог байсан. Одоо больсон, гэтэл хэрэгцээ байдаг, түүнийг яаж шийдвэл дээр вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй жолоочын сургалтын талаар таны бодол
- Хөгжлийн бэрхшээлтэй жолооч гэсэн таних тэмдэг машиндаа тавих талаар хотын дүрэмд байдагч тэр тэмдэг хаана ч, ямар ч хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагддаггүй энэ талаар таны бодол
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн машины зогсоол, тусгай тэмдэг тэмдэглэгээ УБ хотод хаана байдэг вэ?
- Тусгай зогсоол, тэмдэг, тэмдэглэгээ хаана байх ёстой вэ?
- Энэ нь ямар журмаар зохицуулагдах ёстой гэж та бодож байна вэ?

- Автомашин эзэмшигчдээс олон төрлийн татвар авдаг эдгээрээс хөгжлийн бэрхшээлтэй жолоочтой / Хөл орлох унаа / автомашиныг хөнгөлөх, чөлөөлөх боломж бий юу

- Эдгээр асуудалд өөрчлөлт, шинэчлэлт оруулах ямар бодол, санал байна

“Бидний эрх зөрчигдөөд байна” Мониторингийн төсөл

Зорчих бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдийн эрх байнга зөрчигдөж байгаа талаар манайд харъялагддаг иргэдийн олон удаагийн гомдлын дагуу, ялангуяа Хөнгөлттэй нөхцлөөр өөрийн мэдлийн хөл унаатай болчихвол зөрчигдөөд байгаа олон нөхцлүүдийн ихэнх нь хөнгөрөх боломжтой талаар удаа дараа яригдаад байгаа хүсэлтийн дагуу хийгдэж байгаа уг Мониторингийн үйл ажиллагааны эхний ээлжинд Тэргэнцэртэй иргэдийн зорчих нөхцлийг сайжруулах талаар Улсаас нэгдсэн бодлого явуулахгүй байгаа өнөө үед өөрсдийн боломжоороо тусгай тоноглолтой болон гар удирдлагатай автомашинтай болж “хөл орлох унаа”-ныхаа асуудлыг шийдвэрлэн, тэрнээс улбаалан сурч, хөдөлмөрлөх эрх нь нээгдээд, түүнийгээ хэрэгжүүлж яваа зорчих бэрхшээлтэй иргэдийн дунд судалгаа хийж, тэдний одоогийн нөхцөл байдал, туршлага, учирч буй бэрхшээл, түүнийг яаж хөнгөрүүлж болох арга зам байгаа болон, хөл унаагүйн улмаас нийгэмшиж чадахгүй гэрийн хорионд, бусдын хараат байдалд амьдарч байгаа зорчих бэрхшээлтэй бусад иргэдэд жирийн хүмүүсийн адил амьдрах боломж олгохын тулд Зохих хуулинд тодорхой нааштай өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяраар дамжуулан УИХ-д өргөн барьсан бөгөөд эхний хэлэлцүүлгийг амжилттай давж, одоо хаврын чуулганаар хэлэлцэгдэн батлагдахаар төлөвлөгдөөд хүлээгдэж байгаа билээ.

Төсөл хэрэгжилтийн явцад “Хөл орлох унаа”-тай болсоны улмаас ажил, амьдралаа хэвийн авч яваа Улаанбаатар хотын 100 шахам зорчих бэрхшээлтэй жолоочын дунд санал асуулга, судалгаа явуулж эрэлт хэрэгцээг тодорхойлон тэдний санал хүсэлтийг үндэслэн зохих газар, албан тушаалтануудтай уулзан санал солилцон зарим зүйлээр хамтран ажиллах талаар тодорхой тохиролцоонд хүрч, зарим асуудалд зохих өөрчлөлт, шинэчлэлт оруулах талаар ярилцан эхний алхам хийгдээд байна. Үүнд: Авто тээврийн тухай болон Гааль, татварын хуулинд өөрчлөлт шинэчлэлт оруулах, Замын цагдаагийн газар, Авто прожект, Мастер плаза зэрэг газруудтай хөгжлийн бэрхшээлтэй жолоочтой автомашины тусгай зогсоол, тэмдэг тэмдэглэгээ, түүнийг хэрэгжүүлэх журам, баримтлах нормаль нормативыг олон улсын жишгийн дагуу бий болгон мөрдүүлэх, зорчих бэрхшээлтэй жолоочтой автомашины засвар үйлчилгээг хөнгөлттэй нөхцөлөөр график хугацаанд нь чанартай хийх талаар зарим тохиролцоонд хүрээд байна.

Харъяалагдах яамны сайд өөрчлөгдсөнтэй холбогдуулан НХХЯ-ны шинэ сайд Дэмбэрэлтэй уулзан түрүүнд явуулсан мониторингийн тайланг гардуулж, одоо явуулж байгаа мониторингийн талаар санал солилцон, зарим зүйл дээр зөвлөлдлөө.

БНХАУ-д хүн ам олонтойн улмаас зорчих бэрхшээлтэй иргэдэд автомашин хэрэглэхийг зөвшөрдөггүй бөгөөд харин 3,4 дугуйтай моторт болон аккумулятортой цэнэглэдэг дугуйнуудыг үнэ төлбөргүй олгодог бол, БНСУ-ын туршлагаас харахад Хөгжлийн бэрхшээлтэй жолооч нарт бүх нөхцөлд нь 50 хувийн хөнгөлөлт үзүүлдэг харин Япон улс Автомашины ашиглалт, эдэлгээний байдлыг харгалзан үзэж тодорхой хугацаанд машиныг нь шинэчлэн өгдөг байна. Эдгээр орнуудад олон нийтийн үйлчилгээний бүх газруудад тухайн үйлчилгээний байгууллагын орох гол хаалганы хамгийн ойр очих цэгт тусгай зогсоол байгуулсан байдаг агаад, тэр зогсоолд өөр машин зогсохыг хуулиар хориглодог бөгөөд зөрчсөн тохиолдолд өндөр торгууль ногдуулдаг журамтай юм байна.

Зохих албан газрын удирдлагуудтай уулзахад зарим нэг хүндрэл тохиолдож байгаа боловч мониторингийн ажил төлөвлөгөөний дагуу хэвийн явагдаж байна.

Зорьсон асуудлаар ажлаа явуулж, товлосон хугацаандаа амжуулах төлөвлөгөөтэй байгаа ч түүнтэй холбогдуулан өөрчлөн шинэчлэмээр, цаг үедээ зохицуулан шийдүүлмээр, бусад орны туршлага, туслалцааг тусган авч ашигламаар олон чухал асуудал урган гарч ирж байгаа нь ажиглагдаж байна.

Бидэнд тулгамдаад байгаа олон чухал асуудлыг шийдвэрлэх боломж олгон, дэмжлэг туслалцаа байнга үзүүлж байгаа Нээлттэй нийгэм форумын хамт олонд маш их баярлаж байгаагаа илэрхийлж Та бүхний ажилд амжилт хүсье



МОНГОЛЫН
ТЭРГЭНЦЭРТЭЙ ИРГЭДИЙГ
ДЭМЖИХ “ТӨМӨР” САН

“ АВТО ПРОЖЕКТ”
БАЙГУУЛЛАГЫН
Н.ГАНБОЛД ТАНАА

Хаяг: Сонгино Хайрхан дүүрэг 14-р хороо

Ш / Хаяг: Улаанбаатар – 21. ш /х -- 380

Э / шуудан : tumur_san @ yahoo com

Утас: 99125467; Факс: 976 - 11 - 318849

2007.

ДД

Санал хүргүүлэх тухай:

Манай байгууллага нь зорчих бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэдийн эрх ашгийг хамгаалж, тэдний нөхцлийг нь сайжруулан сурч, хөдөлмөрлөх боломжийг нь дэмжиж, ажилгүйдэл, ядуурлаас гарах боломжийг эрэлхийлэн, бусад орны туршлага, туслалцааг түшиглэн хөгжих зорилгоор тэргэнцэртэй иргэдийн өөрсдийн үүсгэл санаачлагаар байгуулагдсан нийгэмд үйлчилдэг олон нийтийн төрийн бус байгууллага юм.

Тус сан нь Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр зорчих нөхцөлийн бэрхшээл хүндрэлээсээ гарах зорилгоор “Бидний эрх зөрчигдөөд байна” төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төсөлд: төрөл бүрийн шалтгаанаар суумгай болсон тэргэнцэртэй иргэд зорчих бэрхшээлээсээ болоод нийгэмшиж чадахгүй, хүний амьдралын наад захын үйлчилгээнд хамрагдах боломжгүй, сурч, хөдөлмөрлөх эрх нь зөрчигдэж, нийгмийн асуудал нь хаалттай байгаад судалгаа хийж, өөрийн орны онцлог байдал, тэргэнцэртэй иргэдийн шаардлага, нөхцөлд тохируулсан тээврийн үйлчилгээг бий болгох, гар буюу автомат удирдлагатай автомашинаар хангах зэрэг зорилгоор энэхүү саналыг хүргүүлж байна.

Улсын хэмжээнд 13.000 тэргэнцэртэй иргэн байдаг гэсэн албан бус тооцоо байдаг.

Тэргэнцэртэй иргэд нь Таксинаас бусад нийтийн тээврээр үнэгүй үйлчлүүлэх үнэмлэх авах эрхтэй ч ашиглах боломжгүй / манай улсын хэмжээнд тэргэнцэртэй хүн зорчих зориулалтын зам, талбай, тэднийг тээвэрлэх лифттэй автобус, троллейбус байхгүй / тул автомашины замаар явах гэхээр нэг бол угаартаж үхчих гээд эсвэл автомашинууд нь шүргэж, дайрч алчих гээд явхад хүндрэлтэй учир зөвхөн таксигаар үйлчлүүлэхээс өөр аргагүй болдог бөгөөд тэтгэврийн цөөн хэдэн төгрөгөө зөвхөн унаанд зарцуулахад 3-5 удаа гадуур гараад л дуусдаг тул нийгмийн цаг үеийн шаардлага, эрэлт хэрэгцээг үндэслэн нийтийн тээврийн үйлчилгээнд бодлогын шинэчлэлт өөрчлөлт зохицуулалт хийхээс гадна, гар буюу автомат удирдлагатай автомашинаар хангах асуудал тавигдаж байгаад дүгнэлт хийж, түүнд зориулсан тусгай зогсоол, тэмдэг тэмдэглэгээ, бусад асуудлаар баримтлах өөрийн орны онцлог тохирсон норм, нормативыг бий болгон мөрдөх журам зэргийг боловсруулах асуудалд Тэргэнцэртэй иргэдийн асуудлаар мэргэшсэн байгууллага болох манай байгууллагын санал, төслийн судалгааг

үндэслэн, хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, нийтийн тээврийн үйлчилгээ болон тэдэнд зориулагдсан “хөл орлох унаанд нь” тохирсон зам тээвэр, хотын дүрэм зэрэг зохицуулалтын асуудалд шинэ ахиц дэвшил гарган ажиллах зайлшгүй шаардлага байгааг сонордуулъя.

Энэ асуудлаар ойрын үед манай удирдах ажилтадыг хүлээн авч санал бодлоо хуваалцах боломж олгоно уу?

Таны ажилд амжилт хүсч хүндэтгэсэн.

Тэргүүн

П.Төмөрбаатар

Хөгжлийн бэрхшээлтэй жолооч нартай хийх фокус группын ярилцлагын төлөвлөгөө

Огноо:2007оны.....сарын.....өдөр

Ярилцлага явуулсан:.....

Ярилцлага тэмдэглэсэн:.....

Эхэлсэн:.....цаг.....минут

Дууссан:.....цаг.....минут

-Амьдрал ахуй ямар байна?

-Та нар одоогоор хөдөлмөр эрхлэж байна уу?

-Та машинаараа орлого олдог уу, Эсвэл тэр таны хөл унаа юу?

-Та нарын орлого амьдралд чинь хэр зэрэг хүрэлцэж байна вэ?

-Та нарын өдөр тутмын амьдралд ямар бэрхшээлтэй асуудал байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй жолооч гэсэн таних тэмдгийг хэрэглэдэг үү? Хэрэглэдэггүй бол яагаад?

-Хөгжлийн бэрхшээлтэй жолоочтой машинд зориулсан зогсоол хаана, хаана байдаг вэ?

-Тийм зогсоол хаана байх хэрэгтэй вэ?

-Замын цагдаа та нартай ямар харьцдаг вэ? Шалтгаан, хандлага

-Засвар үйлчилгээгээ хаана хандаж хийлгэдэг вэ? Үнэ хөлс, Үйлчилгээний чанар ямар байна.Энэ талаар таны бодол

-Татвар даатгалын талаар та нарын бодол

-Гражтай юу? Байхгүй бол яагаад

-Бензин, Тос тосолгооны материалаа хаанаас голдуу авдаг вэ?

-Автомашин угаалгын цэгүүдээр машинаа угаалгадаг уу, үгүй бол яагаад

-Үзлэг, оношлогоонд яаж хамрагддаг вэ?хүндрэл учирдаг уу?

-Энэ чиглэлээр төрөөс ямар үйлчилгээ хүсч байна вэ?

-Жолооны сургалтын талаарх та нарын бодол

-Автомашинтай холбоотой өөр ямар санал бодол байна вэ?

-Жолооны дүрэмд зохицохгүй зүйл байна уу? Эсвэл тэнд оруулах өөрчлөлтийн ямар санал байна вэ?

-Аль улсын машин эдэлгээ сайтай, өртөг багатай байна вэ?

-Жолооны ямар удирдлага та нарын шаардлагыг хангаж байна вэ?

Төслтэй холбогдуулан уулзах албан газар, албан тушаалтан

1. Зам тээвэр аялал жуулчлалын яам
2. Нийслэлийн зам тээврийн газрын дарга Д.Бат-Эрдэнэ
3. Нийслэлийн нийтийн тээврийн газрын дарга Сайханбаяр
4. ЗЦГ
5. Авто прожект Ганболд /МҮХАҮТанхим 907 тоот/
6. УБ хотын гүйцэтгэх захиргаа

Хөгжлийн бэрхшээлтэй жолооч нарын бүртгэл

дд	Овог нэр	Бэрхшээл Хүйс, Гэрийн хаяг	Утасны дугаар	ИҮ-ийн Дугаар Регестер	Машины марк, Улс	Улсын дугаар	Группын дэвтэр, Жолооны үнэмлэх
1.	Шагдарсүрэн Эрдэнэбилэг	ННГ эр ЧД 5-рх,6-р хороолол 5-6	329336г	УБ025062 9 ШБ60082 517	TOYOTA Japan		
2.	Шинрэнэн Цогцэцэг	ННГ эм СБД 2-рх, 5-р х 14Б 1-6	329424г 99882989	УБ041985 7 УШ57011 509	Japan		005507
3	Жагар Баасанжав	2 хөл Гуяа эр БЗД 16- рх, Тз 8-8	99293066	УБ002764 0 ЕЙ570109 14	TIKO KOREA	42-38 УБЛ	024577
4	Авирмэд Энхээ	ННГ эр СХД 16-рх, 27-16	684748г	УБ030206 9 ЧТ610625 10	RVR Japan		
5	Пүрэвжал Төмөрбаатар	ННГ эр СХД 14-рх, 1-14-182	9912 - 5467	УБ02426 24 ЧП520604 75	TOYOTA RAUM Japan 98	37- 92 УБЦ	0155121
6	Гомбожав Яю	ННГ эм СБД 16-рх, Ойчидын 2—34-2	3577421		Фиат-126 Польш		
7	Ганзориг	2 хөл шилбэ эр	88824848		DELIKA Japan		
8	Амаржаргал	эр	96667307				
9	Энхбаяр	Саажилт 2 С.таяг эр			Ланд крузер		

10	Цэдэн Оюунбаатар	Т/ гэмтэл Эр ХУД	99272482	УБ148186 ҮИ590716 71	BMW Герман		01854799
11	Довдон Сонгохбаяр	Саажилт 1 С.т эр СБД 16-рх бэлхийн 18- 437			EXCEL KOREA		
12	Санж	Саажилт суумгай эр	99841922		TOYOTA	30-13	
13	Давгадорж Дашзэвэг	Б.хөл про эр БГД 13- рх3-р хороолол 2--37	364007г		Вольво-340 Швед	18-82 УБМ	
14	Раашмягмар Баримида	ННГ эр БГД 7- рх,4-р хороолол 31-72	361058г 99656045		Japan subaru	95-68 УБЯ	
15	Сандаг Ганболд	ННГ эр СБД 11-рх 7.5.8	351435г	УБ041041 4 ЧП650808 11	RVR Japan ,	21-39 УБД	-
16	Хувбор Баясгалан	Хөл гуяа эр	632880г				
17	Отгон Наранчимэг	ННГ эм СХД 4-рх Их наран 34-36	99296350	УБ000445 4 УБ701008 06	EXCEL KOREA	18-46 УБД	-
18	Гүнжилмаа	Б.Хөл гуяа эм			Акцент		
19	Схамбалхүнд эв Эрдэнэчулуун	Түнх эр	88833166		Japan	25-60	
20	Ширээ Ганбаа	ННГ эр	99158400		Japan Toyota korolla		
21	Галсан Бандихүү	НГ эр	99742383	БХ633989 УУ677091 714	RVR Japan		
22	Санжравдан	ННГ эр			Микроавтоб ус		

23	Тогоохүү Цэдэнбал	Сонсголгү й эр БГД	9978- 4925		Estana		
24	Даваадорж	Саажилт 2 С.таяг эр			Запрожец		
25	Сергей Ёндон Гомбожав	Б хөл гуяа Эр ХУД 2- рх	99772778		Марк- 2		

26	Лувсандорж Нэргүй	ННГ эр ХУД19-рх, 2-16	343741г	УБ0206195 ЧН4705251 9	Nissan Mikra 84	10-74 УБИ	31808
27	Төгсбаяр	Түнх эм					
28	Долгорсүрэн Бадамханд	Саажилт 2 .таяг эм СБД 4-рх, 50.0-22-40	316014г	УБ0388611 У0661222 8			0735041
29	Пүрэвдоо	Сонсголгү й эр			Japan		
30	Майдаржав Раднаадагий	2 хөл эм СХД19- рх,21-р хороолол 1-16	634752г 99897034		Japan		
31	Хөвсгөл	эр					
32	Өвгөн	эр					
33	Найрамдал баазын дарга	эр					
34	Мөнхбат	Хөл эр			Газ-24 Орос	38-60 УБИ	Хархорин
35	Жанчивдорж	эр			NISSAN SANNY	59-84 УБА	Дамбадар жаа
36	Өнөрбаяр	Сул хараа Тай эм	99041745		Даймонд		
37		Төрөлхий н эм			VAUXAL L	10-70 УБИ	

	Б.Дуламжав				ОPEL 89		
38	Лхасранжав Цэцэгжаргал	ННГ эм ХУД 9-рх, Буянт- Ухаа10- 413	379912г	ЧИ6808307 1	EXCEL KOREA	38-.08 УБГ	
39	Ялагдашгүй	Хөл эр	21- 244248г		элентра		
40	Б Пүрэвжав	Б.гар эр саажилт	99864576 681729г		Соната Марк-2 Бонго	71-81 УБТ 20-21 УБК 88-42 УБ	
41	Билэгсайхан	Протез эр	9928- 4057		Марк-2		
42	Гүнчин- Иш	эр	91818100		Запроже ц 87	63-88 УББ	
43	Цогбуян	эр	99827997		Nissan	74-66 УБЛ	
44	Базаррагчаа Болдхуяг	ННГ эр БГД 5-рх, 10-р хороолол 8-2-451	687853г	УБ0173687 ШБ600927 11	япон		
45	Цэрэндаш Энхтуяа	ННГ эм БГД 3-р Хороолол 5-137	363138г	УБ165867 АЯ6103136 7	Акцент		
46	Батзогсох Арвинбуудай	ННГ эм БГД 10-рх, 16-68	304436г	УБ0167134 ЧО741214 02...	Чезер		
47	Гармаа Амгалан	Полиомел ит эр БЗД 16-рх, Энэрэлий н задгай	99167511 99294452	УБ032537 ХМ571015 18	запроже ц		
48	Батмөнх Төгөлдөр	Саажилт эр БЗД эмч нарын байр 212			эксел		

54	Бужаа Оюун	Төрлөхий н эм Бага-нуур			Запроже ц		
55	Пүрэв Ганзориг	ННГ эр Төв аймаг 1-рх 28-44					
56	Батмөнх	ННГ эр			Прадо		
57	Батсайхан Баярбат	Саажилт эр БГД 1-рх, 54-8	369277г 99192596 аав нь				
58	Рэнцэндаш Бүүвэйбаатар	ННГ эр БГД 11-рх зүүн Ард Аюуш 8-52	99299336		Микро автобус	61-44 УБЭ	
59	Мягмар Баясгалан	Нурууний гэмтэл эр БГД 6-рх Турк коллежийн байр 116	95154727	УБ206150 ЧП5609301 6	элэнтра		
60	Пүрэвдорж Мягмарцогт	ННГ эр ЧД 18-рх, Яргайтын 6-71			Япон		
61	Долгоржав Дондогдулам	ННГ эм БЗД 16-рх, 9-9	451342г	УБ078425 ЧИ6301116 7	Япон		
62	Нацагдорж Надмид	ННГ эр БЗД 6-рх, Амьны орон сууц 13-1--5	460649г	УБ0002004 7 ШБ500519 976	Япон		
63	Батаахүү Баяраа	ННГ эр БЗД17-рх, Эрдэнэтол гой 32-871		УБ0105106 ЦА6304291 2			
64	Лхагва Жанчивдорж	саажилт	99147784		Nissan sanny		

Монголын тэргэнцэртэй иргэдийг дэмжих "Төмөр" сан.

Бусдын унаагаар
Өөрийн

14. Үнэгүй зорчих эрхийн үнэмлэх хэрэглэдэг үү? Тийм
Үгүй /Тодруулна уу?/.....
.....
.....

15. Тэргэнцэртэй иргэд ямар тээврийн хэрэгсэлээр зорчвол тохиромжтой вэ?
Лифттэй автобус
Тусгай тоноглолтой машин
Гар удирдлагатай автомашин
4 дугуйтай мотоцикль
Тусгай зориулалтын дуудлагын такси
Бусад

16. Нийтийн тээврийнхэн ямархуу хандаж байна? Сайн
Хэвийн
Тааруухан
Муу
Бусад / Тодруулна уу?/
.....

17. Та өөрийн машинтай больёо гэвэл ямар нөхцлөөр авах вэ? Бэлнээр
Лизенгээр
Түрээсээр
Бусад

18. Та машинтай бол зардлаа яаж зохицуулдаг вэ? Цалингаараа
Тэтгэвэрээрээ
Бусдын туслалцаатай
Машинаараа
Бусад

19. Танд ямар нэмэгдэл тусгай тоног төхөөрөмж шаардлагатай вэ?
.....
.....
.....
.....

20. Таны эрх зөрчигдөж байгаа эсэх Тийм / Тодруулна уу?/.....
.....
.....

21. Танд байнгын асрамжлагч хэрэгтэй байдаг уу? Тийм /тодруулна уу?/
.....
.....

22. Автомашин түүнийг ашиглахтай холбоотой ямар санал бодол байна вэ?
Үгүй.

23. Тусгай зогсоол, тэмдэг тэмдэглэгээний талаар

24. Татвар, даатгалын талаар

25. Засвар үйлчилгээний талаар

26. Жолооны сургалтын талаар

27. Шатах, тослох материалын талаар

28. Хотын дүрмийн талаар

29. Бусад асуудлаар

ТАНД БАЯРЛАЛАА.

Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх одоо мөрдөж байгаа Олон улсын болон манай улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц

1. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1975 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай тунхаглал”-ын 8-д : - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн онцгой хэрэгцээг эдийн засгийн болон нийгмийн бүхий л шатанд тусгуулах эрхтэй гэж заажээ.
2. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 48-р чуулганы 48/96 тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст адил тэгш боломж олгох үндсэн зарчим”-н 26-д: - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн гишүүний хувьд өөрийн хүссэн газраа амьдрах эрхтэй. Тэд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний ердийн системийн хүрээнд шаардлагатай дэмжлэг авах ёстой гэж заажээ.
3. Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1991/26-р тогтоолыг биелүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай эрх тэгш байх тухай дэлхий дахины үйл ажиллагааны хөтөлбөрт дурдсан тодорхой арга хэмжээнүүдийг удирдлага болгож,

А/ Хөгжлийн бэрхшээлтэйгийн салбарт авч байгаа бүх арга хэмжээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын нөхцөл, тусгай хэрэгцээний талаар бүрэн дүүрэн сайн мэдлэг туршлагатай байхыг шаарддаг гэдгийг цохон заах,
Г / Техник эдийн засгийн хөгжил, улс төр соёлын амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцох эрх үүргийг харгалзан энэ үйл ажиллагааг явуулах олон хувилбарт санал дэвшүүлэх,

Е/ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст адил тэгш боломж олгох талаар улс орнуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээг үр ашигтай хянах, үр ашигтай механизмыг санал болгох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст адил тэгш боломж олгох Үндсэн зарчмыг дор дурдсанаар батлав гээд

“ЭРХ ТЭГШ ОРОЛЦООНЫ УГТВАР НӨХЦӨЛҮҮД”-ийн 4-р ЗАРЧИМ

Туслах чанарын үйлчилгээнүүд

Өдөр тутмын амьдралд бие даах түвшнийг нь дээшлүүлэх, эрхээ хэрэгжүүлэхэд нь тус дэмжлэг үзүүлэхийн тулд ХБХүмүүсийг туслах чанарын үйлчилгээгээр, түүний дотор туслах хэрэгсэлээр хангах, боломжийг өргөжүүлэх нөхцөлийг улс орнууд хангах ёстой.

1. Улс орнууд ХБХүмүүсийн хэрэгцээг харгалзан туслах нөхөн орлуулах багаж хэрэгсэл, орчуулагчын үйлчилгээгээр хангах ёстой, учир нь эдгээр арга хэмжээнүүд адил тэгш бололцоо нөхцөл олгоход чухал үүрэг гүйцэтгэнэ.
2. Улс орнууд туслах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж боловсруулах, үйлдвэрлэх, хуваарилах, тэдгээрээр үйлчилгээ хийх, тэдгээрийн тухай мэдээлэл түгээх ажлыг дэмжих ёстой.
3. Үүний тулд байгаа техник, мэдлэг, туршлагыг ашиглах шаардлагатай. Технологийн өндөр хөгжилтэй орнуудад туслах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийн чанар, үр ашгийг дээшлүүлэхийн тулд технологийн нөөц болоцоог бүрэн дүүрэн ашиглах шаардлагатай. Боломжоороо орон нутгийн материал, орон нутгийн үйлдвэрлэлийн баазыг энгийн хямд үнэтэй багаж хэрэгсэл боловсруулах, үйлдвэрийг дэмжих нь чухал Тийм багаж хэрэгслүүдийг үйлдвэрлэх ажилд ХБХүмүүсийг өөрсдийг нь татан оролцуулж болох юм.
4. Улс орнууд туслах багаж хэрэгсэл шаардлагатай бүх ХБХүмүүст тэдгээрийг авч ашиглах, түүний дотор санхүүгийн боломжийг олгох буюу ХБХүмүүс, тэдний гэр бүлийнхэнд болмжтой бага үнээр өгөх хэрэгтэй

7. Ганцаарчилсан тусламжийн хөтөлбөрийг ашиглаж буй ХБХүмүүс нь эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлбэрүүдэд шийдвэрлэх нөлөө үзүүлэх боломжтой байхууцаар боловсруулах нь зүйтэй.

“АДИЛ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ ЗОРИЛТОТ САЛБАРУУД”

Хүрэх боломж.

Нийгмийн амьдарлын бүх салбарт ХБХүмүүст адил тэгш боломж олгох нөхцөлийг бий болгох явцад түүнд хүрэхболомжоороо хангахын чухалыгулсууд хүлээн зөвшөөрөх ёстой.

А/ Хүрээлэн байгаа орчинг ашиглах боломж

1.Хүрээлэн байгаа орчноо ашиглахад саад болох бэрхшээлүүдийг арилгах арга хэмжээг улс орнууд авах ёстой. Тийм арга хэмжээнүүдэд орон сууц барилга, нийтийн тээврийн үйлчилгэ, бусад тээврийн хэрэгсэл, гудамж, гудамжны ойр орчны бусад объектууд нийтийн янз бүрийн салбарт хүрэх боломжоор хангахад чиглэгдсэн хууль тогтоомж баримтуудыг баталгаажуулах асуудлыг авч үзэх, баримтлах стандарт, удирдамж болгох зарчмуудыг боловсруулах зэрэг арга хэмжээнүүдийг оруулах хэрэгтэй.

3.Материаллаг орчныг хангах төсөл нь ХБХүмүүсийн чадвар боломжинд тохирсон байх шаардлагыг тавих хэрэгтэй.

4.ХБХүмүүсийн хувьд МАТЕРИАЛЛАГ ОРЧИНДОО ХҮРЭХ БОЛОМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ СТАНДАРТ НОРМЫГ БОЛОВСРУУЛАХДАА ХБХүмүүсийн БАЙГУУЛЛАГУУДТАЙ ЗӨВЛӨЛДӨНӨ. Нийтийн объектыг барих төслүүдийг боловсруулахдаа ХБХүмүүст ХОЛБОГДБХ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ НЬ НИЙЦСЭН БАЙХААС ГАДНА ХБХүмүүсийг БҮР ЭХНЭЭС НЬ ГАЗАР ДЭЭР НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАТАН ОРОЛЦУУЛАХ нь зүйтэй. Энэ нь ХБХүмүүсийн хувьд материаллаг орчиндоо хүрэхэд дээд зэргийн боломжийг бүрдүүлэх болгоно.

7-р ЗАРЧИМ

ХБХүмүүс ӨӨРСДИЙН ЭРХЭЭ ЯЛАНГУЯА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖООР ХАНГАГДАХ ЁСТОЙ гэсэн зарчмыг улс орнууд хүлээн зөвшөөрнө. Тэд нар хөдөө орон нутагт ч, хотын дүүргүүдэд ч хөдөлмөрийн зах дээр үйлдвэрлэлийн болон орлоготой хөдөлмөр эрхлэх адил тэгш боломжтой байх ёстой.

1. Хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь хууль дүрэм нь ХБХүмүүсийн ялгаварлан гадуурхах ёсгүй бөгөөд тэднийг ажилд авахадсаад бэрхшээл үүсэх ёсгүй.
2. ХБХүмүүсийг хөдөлмөрийн чөлөөт зах зээлд оруулах явдлыг улс орнууд идэвхтэй дэмжих ёстой.

14-р ЗАРЧИМ

Бодлого боловсруулалт болон төлөвлөлт

Улс орнууд бодлого болон үндэсний төлөвлөлтийн бүх талыг боловсруулах явцдаа ХБХүмүүстэй холбогдох асуудлуудыг тооцох нөхцөлийг хангана.

1.Улс орнууд үндэснийхээ хэмжээнд ХБХүмүүсийн эрх ашгийг хамгаалсан зохих бодлогыг төлөвлөн боловсруулж хэрэгжүүлэх бүс нутгийн болон орон нутгийн хүрээндавах арга хэмжээнд тус дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.

2.Улс орнууд ХБХүмүүст холбогдсон тэдний эдийн засаг, соёлын байдлыг хөндсөн ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБОГДОХ БҮХ БОДЛОГО БОЛОВСРУУЛАХАД ХБХүмүүсийн БАЙГУУЛЛАГУУДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ НЬ ЗҮЙТЭЙ.

3. ХБХүмүүсийн ХЭРЭГЦЭЭ СОНИРХОЛЫГ ТУСАД НЬ АВЧ ҮЗЭХ БУС БОЛОМЖИЙН ХИРЭЭР ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНҮҮДЭД ОРУУЛАХ ХЭРЭГТЭЙ

4. ХБХүмүүсийн байдлын талаар ТӨР ЗАСГИЙН ХҮЛЭЭХ ҮНДСЭН ХАРИУЦЛАГА
БУСАД БАЙГУУЛЛАГА ХҮМҮҮСИЙГ ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХГҮЙ
15-Р ЗАРЧИМ

Хууль тогтоомж

Нийгмийн амьдралд ХБХүмүүсийг бүрэн оролцуулах оролцоо болон тэдний эрх тэгш байдлыг хангах зорилгоор арга хэмжээ авах, хууль эрхийн үндсийг бий болгох үүрэг хариуцлагыг төр засаг хүлээнэ.

1. Иргэдийн эрх, үүргийг тодорхойлсон үндсэн хууль, бусад хууль тогтоомжинд ХБХүмүүсийн эрх үүргийг тусгасан байх ёстой. ХБХүмүүсийг ялгаварлан гадуурхах аливаа заалтыг устгах шаардлагатай.

Б/ Тодорхой салбарт хамрагдах хуулиудад ХБХүмүүстэй холбогдох асуудлыг оруулах

16-р ЗАРЧИМ

Эдийн засгийн бодлого

Төр засаг нь ХБХүмүүст адил тэгш байх боломж бий болгох үндэсний хөтөлбөрүүд, арга хэмжээний санхүүгийн хариуцлага хүлээнэ

1. Улс орнууд нийт үндэсний болон, орон нутгийн төрийн байгууллагуудын ердийн төсөвт ХБХүмүүстэй холбогдох асуудлуудыг оруулах хэрэгтэй.
2. Улс орнууд засгийн газрын бус болон бусад СОНИРХОСОН БАЙГУУЛЛАГУУД ХБХүмүүстэй ХОЛБОГДСОН ТӨСЛҮҮД, АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР БИЕ БИЕТЭЙГЭЭ ХАМТРАН АЖИЛЛАХ ХЭРЭГТЭЙ.
3. Улс орнууд ХБХүмүүс НИЙГМИЙН АМЬДРАЛД АДИЛ ТЭГШ ОРОЛЦОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР ЭДИЙН ЗАСГИЙН АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ (ЗЭЭЛ, ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ, ЗОРИЛТОТ ТАТААС, ТУСГАЙ САН г.м) хэрэглэх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

5. Олон улсын хувьд анхан шатны түвшинд янз бүрийн туршилтын төслүүд болон өөрөө өөрийгөө дэмжих хөтөлбөрүүдийг дэмжиж ХБХүмүүст туслах сан байгуулах

17-р ЗАРЧИМ

Үйл ажиллагааны зохицуулалт

ХБХүмүүстэй холбогдсон асуудлаарх үндэсний зохицуулах төв болгон ашиглах үүднээс Үндэсний Зохицуулах Хороодыг буюу түүнтэй төстэй байгууллагуудыг бий болгох бэхжүүлэх талаар төр засаг хариуцлага хүлээнэ.

1. Үндэсний зохицуулах хороо болон түүнтэй адил байгууллагуудын үйл ажиллагаа тогтмол шинж чанартай байх ба хуулийн мөн түүнчлэн холбогдох захиргааны журмаар зохицуулагдана.
2. Тийм хороог салбар хоорондын ба асуудал хоорондын бүрэлдэхүүнтэй болгохын тулд түүнд хувийн болон байгууллагуудын төлөөлөгчдийг оруулах нь зүйтэй. Төлөөлөгчдийг холбогдох яамд ХБХүмүүсийн байгууллагуудаас авч болох юм.
3. ХБХүмүүсийн байгууллагуудад ӨӨРСДИЙНХӨӨ ХЭРЭГЦЭЭГ ЗОХИХ ЁСООР АНХААРУУЛАХЫН ТУЛД үндэсний зохицуулах хороодын үйл ажиллагаанд томоохон нөлөө үзүүлэх боломж олгох хэрэгтэй.
4. Үндэсний зохицуулах хороонд өөрийн шийдвэр гаргах эрхтэйгээ холбогдуулан үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх хангалттай бие даасан эрх олгох ёстой. Хороо нь өөрийн ажлаа засгийн газрын хамгийн дээд түвшинд тайлагнан танилцуулах хэрэгтэй.

18-р ЗАРЧИМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд

Улс орнууд ХБХүмүүсийг үндэсний буюу нутгийн болон орон нутгийн хэмжээнд төлөөлөх ХБХүмүүсийн байгууллагын эрхийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Улс орнууд мөн ХБХүмүүсийн асуудлаар шийдвэр гаргахад ХБХүмүүсийн байгууллагуудын гүйцэтгэх зөвлөлийн үүрэг ролийг хүлээн зөвшөөрнө.

1. Улс орнууд ХБХүмүүс, тэдний гэр бүлийнхэн буюу эрх ашгийг нь хамгаалагч хүмүүсийн байгууллагуудыг бий болгон бэхжүүлэхийг эдийн засгийн талаар болон бусад аргаар урамшуулан дэмжих хэрэгтэй. Эдгээр байгууллагууд нь Хөгжлийн бэрхшээлтэйгийн асуудлаар бодлого боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

2. Улс орнууд ХБХүмүүсийн байгууллагуудтай холбоо тогтоож төр засгийн хэмжээнд бодлого боловсруулахад тэдний оролцох нөхцлийг хангах хэрэгтэй.

3. ХБХүмүүсийн байгууллагууд тэдний эн тэргүүний хэрэгцээт зорилтуудыг тодорхолж, амьдралтай нь холбогдох үйлчилгээний арга хэмжээнүүдийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлэлтэнд оролцох

19-р ЗАРЧИМ

Боловсон хүчин бэлтгэх

Улс орнууд ХБХүмүүст холбогдсон хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэхэд оролцогч бүх шатны байгууллагууд боловсон хүчнээ зохих ёсоор сургаж бэлтгэх талаар хариуцлага хүлээнэ.

1. ХБХүмүүст үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллагууд өөрсдийн боловсон хүчнээ бэлтгэж, сургах нөхцөлийг улс орнууд хангана.

2. ХБХүмүүстэй холбогдох асуудлаар мэргэжилтэн бэлтгэх олон нийтийн боловсролын хөтөлбөрүүдэд ХБХүмүүстэй холбогдох мэдээлэл оруулахдаа тэгш эрхийн болон бүрэн эрхийн оролцооны зарчмыг хэрэгжүүлэх ёстой.

21-р ЗАРЧИМ

Техник эдийн засгийн хамтын ажиллагаа

3. Техник эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг төлөвлөх, дахин авч үзэхдээ ХБХүмүүсийн байранд тийм хөтөлбөрүүдийн нөлөөлөлд онцгойлон анхаарах хэрэгтэй. ХБХүмүүст зориулан зохиосон аливаа хөгжлийн төслүүдийн талаар ХБХүмүүс тэдний байгууллагуудтай зөвлөлдөх явдал маш чухал ач холбогдолтой. Тэд тийм төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэн, үнэлэхэд шууд оролцох ёстой.

22-р ЗАРЧИМ.

3. Улс орнууд дараах байгууллагуудын хооронд мэдлэг мэргэжлийн солилцоо явуулахыг урамшуулан дэмжих ёстой. Үүнд:

а/ Хөгжлийн бэрхшээлтэйгийн асуудлуудтай холбогдох засгийн газрын бус байгууллагууд

б/ Хөгжлийн бэрхшээлтэйгийн асуудалд оролцогч судалгааны байгууллагууд, хувь судлаачид

в/ Орон нутаг дахь хөтөлбөрийн төлөөлөгчид ба ХБХүмүүсийн асуудал эрхэлсэн мэргэжлийн бүлгүүд

г/ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд

д/ Үндэсний зохицуулах хороод

4. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд мөн түүнчлэн ЗГ хоорондын болон парламент хоорондын бүх байгууллагууд дэлхий нийтийн болон бүс нутгийн хэмжээнд ХБХүмүүсийн дэлхийн буюу бүсийн байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулах нөхцөлийг хангах хэрэгтэй.

Ази, номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссын 2002 оны 58/4 тоот тогтоолоор 2003-2012 оныг Ази, номхон далайн бүсийн ХБИргэдийн аж байдлыг сайжруулах тэдний оролцоог хангасан, саад тотгоргүй, эрхэд тулгуурласан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилго бүхий “Ази, номхон далайн бүсийн ХБИргэдийг дэмжих 10 жил болгосон. Энэ үйл ажиллагааны “БИВАКОГИЙН МЯНГАНЫ ХӨТӨЛБӨР”-т:

Шийдвэрлэх асуудлууд

16. ХБИргэд өөрсдийгөө дэмжих, харилцан мэдээлэл авах, солилцох, сурталчлан танилцах гэх мэт бүхий л талуудаар бэлтгэгдсэн, бүрэн дэмжлэгтэй байх ёстой.

ХБИргэд өөрсдийнхөө эрх ашгийнхаа төлөө дуу хойлоогоо идэвхтэй гаргах аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байх тохиолдолд ХБИргэд болон тэдний хамт олны амжиргааны чанар дээшлиж байдгийг үйл явц харуулж байна. Холбогдох хууль эрхийн актууд, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд ХБИргэдийн байгууллагууд чадварлаг оролцох, мэдээлэлтэй байх, өөрсдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг идэвхтэй тусгуулах нь тэдний нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд бүрэн оролцох бололцоог бий болгодог бөгөөд өөрийн хамт олныхоо хөгжилд хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ.

17. Өөрсдийн төлөөлөлийг бий болгох, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг ойлгож хамгаалах, аливаа шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцох чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна.ХБИргэд өөрсдийн хэрэгцээ шаардлагыг гаргаж тавих, шинэчлэл, өөрчлөлтийг сурталчлах нь тэдний хөгжилд тодорхой хувь нэмэр болох бөгөөд өөрсдийн нийгэм хамт олны дунд бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх юм.

18. ХБИргэдийн төлөөллийн хөдөлгөөн, ардчиллыг хөгжүүлэх нь нэг талаар ХБИргэдийн хэрэгцээ, шаардлага, эрхийг хамгаалах талаар Засгийн газрын гүйцэтгэх үүрэг болох ёстой

Е.Баригдаж бий болсон барилга байгууламж, нийтийн тээврийн хангамжийн хүртээмж.

1. Шийдвэрлэх асуудлууд

35. Нийтийн тээврийн хэрэгсэл болон аль хэдий нь баригдаж бий болсон барилга байгууламэид нэвтрэх боломжгүй байдал, ХБИргэдийн амгалан тайван байх, бүс нутгийн орнуудын нийгэм эдийн засгийн бодлогод тэдний идэвхитэй оролцоход саад тотгор болж байна.Баригдаж бий болсон барилга байгууламж, гудамж зам талбай, тээврийн хэрэгсэлээр зорчих боломжгүй байгаа явдал ХБИргэд, нийгмийн бусад гишүүдийн хооронд ялгааг буй болгож байна.

4.ЗОРИЛТ 13

Засгийн газрууд тарийн болон нийтийн байгууламжууд, дэд бүтэц, хот хөдөөгийн тээврийн үйлчилгээгХБИргэдийн онцлог хэрэгцээнд тохирох байдлаар тоноглон зохион байгуулах

ЗОРИЛТ 14.

Бүх шинээр бий болж байгаа буюу шинэчлэгдэж буй нийтийн тээврийн хэрэгсэл, зам, усан хангамж, гэрэлтүүлэг, төмөрзам, агаарын тээврийн системүүд ХБИргэд, ахмад настнуудын хэрэгцээнд тохирсон байдлаар зохион байгуулагдах, өнөөгийн ашиглагдаж байгаа газар, усан хангамж, агаарын тээвэр/машины зогсоол, зогсоолууд, дамжин өнгөрөх орцууд/ХБИргэдийн хэрэгцээг хангах, өөрчлөлтийг аль болох түргэн, боломжийн байхаар зохион байгуулах.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ СТАНДАРТ ДҮРЭМ. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48-р чуулганаар баталсан 1993 он

Дүрэм4. Туслах үйлчилгээнүүд

ХБХүмүүсийг өдөр тутмын үйл ажиллагаанд бие дааж оролцох түвшинг дээшлүүлэхэд нь мөн өөрсдийнхөө эрхийг эдлэхэд нь туслахын тулд ХБХүмүүсийн ТУСЛАХ ХЭРЭГСЭЛ зэрэг үйлчилгээгээр хангах, хөгжүүлэхийг улс орнууд баталгаажуулах ёстой.

1. Тэгш боломжинд хүрэх чухал арга хэмжээнүүд болох ТУСЛАХ ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, хувийн тусламж, орчуулгын /хэлмэрчийн/ үйлчилгээнүүдийг ХБХүмүүсийн хэрэгцээнд үндэслэж хангахыг улс орнууд баталгаажуулах ёстой.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС 1992

16-Р ЗҮЙЛ

1. Амьд явах эрхтэй.
2. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй
3. Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шудрагаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй
4. Ажил мэргэжилээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах
6. Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлэгийн тусламж авах эрхтэй Иргэдэд эмнэлэгийн төлбөртэй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно.
7. Сурч боловсрох эрхтэй
13. Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй.
16. Итгэл үнэмшилтэй байх
18. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхтэй.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛД 2005

1-Р ЗҮЙЛ Хуулийн зорилт

- 1.1 Энэ хуулийн зорилт нь ХБИргэний нийгмийн баялагаас хүртэх эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд тэгш оролцох боломж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэн сурч, хөдөлмөрлөх. нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, ХБИргэнд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээг тогтоох, энэ талаар иргэн хуулийн этгээдийн үүргийг тодорхойлоход оршино

2-р зүйл

- 2.1. ХБИргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ

3-р зүйл. Хуулийн нэр томъёо

- 3.2 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж таралхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, осол гэмтлийн улмаас бие эрхтэн, оюун ухаан, сэтгэц, тулах хөдлөх эрхтэн, мэдрэхүйн чадавх нь амьдрах хөдөлмөрлөх боломж хязгаарлагдсан нь тогтоогдсон хүнийг хэлнэ.

2-р бүлэг

- 4.2.4 Харах, сонсох, ярих боломж нь хязгаарлагдсан сурагчийн тусгай сургуульд суралцахаар харгалзан дэмжигч нэг хүэний хамт ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлнө
- 4.3 ХБИргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/ -ээр авто тээврийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу үнэ төлбөргүй буюу хөнгөлттэй үнээр зорчино.
- 4.4 ХБИргэн худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний газраар эхний ээлжинд үйлчлүүлнэ.

8.3.3 Нийтийн тээврийн хэрэгсэл, төмөр зам, орон сууц, албан байгууллага, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц гэрэлтүүлэг, бие засах газрын зорчих хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хязгаарлагдмал боломжид тохируулан хийх

ГААЛИЙН ТАРИФИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАС 1996

21-Р ЗҮЙЛ

Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа

21.1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, материал, түүхий эд

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИАС 1992

2-Р БҮЛЭГ

9/ Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИАС 2004

9-Р ЗҮЙЛ

Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх

9.1.15 Хараагүй, дүлий болон тулах эрхтэний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувь алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний орлого

БАТЛАВ

П.ТӨМӨРБААТАР /Сангийн тэргүүн/

АЖИЛ ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭ

Энэхүү гэрээг Төмөр сан ТББ /цаашид А тал буюу Төмөр сан гэх/.....
/цаашид Б тал буюу гүйцэтгэгч гэх/ нарын хооронд дараах зүйлийг харилцан тохиролцож
2007 оны ... сарын ... ны өдөр /цаашид гэрээ гэх/ байгуулав.

НЭГ: Нийтлэг үндэслэл

- 1.1 “Төмөр сан” ТББ нь зорчих хүндрэл бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэдийн эрх ашгийг хамгаалж , тэргэнцэртэй иргэдийн сурч, хөдөлмөрлөх нөхцлийг нэмэгдүүлж, тэдний ажилгүйдэл, ядуурлыг бууруулан амьжиргааг нь дээшлүүлж бусад орны туршлага, туслалцааг түшиглэн хөгжих зорилготой үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллага юм.
 - 1.2 ННФ-ийн Төсөлд хамрагдсанаар: Тусгай тоноглолтой, гар удирдлагатай автомашины захиалга, нийлүүлэлт, хувиарлалт, гаалийн болон онцгой албан татвар, нэмүү өртгийн татвар, жишиг үнийн татвар, автомашин ашиглалтын болон зам тээвэр, зам ашиглалтын татвар, бусад элдэв төлбөр, татвар хураамж, гувчуурыг олон улсад хэрхэн мөрддөг болон манай улсад энэ талаар хуулийн ямар бодлого баримтлан ажилладаг, төрийн ямар хөнгөлөлт үйлчилгээ байдаг, тэр нь зорчих бэрхшээлтэй иргэдэд хэрхэн хүрч үйлчилдэгт мониторинг хийж, энэ талаарх хуулийн хэрэгжилт, төрийн тусламж үйлчилгээний үйл ажиллагаа шудрага, авилгалаас ангид байгаа эсэхийг тодруулах, гарч буй зөрчлийг арилгах арга замыг тодорхойлох, төрийн тусламж үйлчилгээг шинэчлэх санал боловсруулах
 - 1.3 А тал нь Б талыг төслийн баримт бичигт заасан ажил, чиг үүргийг биелүүлэхээр уг гэрээг байгуулав.
 - 1.4 Энэхүү гэрээг 2007 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн 2 /хоёр/ сарын хугацаатай байгуулав.
- Талууд доорхи зүйлийг харилцан тохиролцов.

ХОЁР: Б талын гүйцэтгэх ажил

2.1 Төслийн багийн зөвлөх нь төслийн төлөвлөсөн ажлын хуваарийн дагуу хариуцан гүйцэтгэх ажлаа чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх ба цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд оролцох, шаардлагатай тохиолдолд нэмэлт ажилтаныг авч ажлыг товлосон хугацаанд нь багтаан гүйцэтгэнэ.

2.2 Төслийн баримт бичигт заасан мониторинг хийх бүх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох ба санаачлага гарган ажиллана.

2.3 Төслийн зөвлөхөөр ажиллах явцадаа үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл, шинэ санаачлага, НОУХАУ, томъёолол, судалгаа, шинжилгээ, төлөвлөгөө, бусад өгөгдөл, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалж бусад байгууллага, хувь хүнд задруулахгүй, “Төмөр сан”-гаас өөр этгээдийн ашиг тусын тулд дээрх зүйлийг ашиглахгүй.

ГУРАВ: А тал буюу /Төмөр сан/ гүйцэтгэх үүрэг

3.1 Төслийн хэрэгжилтийг хангахад бүхий л бололцоотой нөхцлийг бүрдүүлэх

3.2 Энэхүү Гэрээнд заасан ажлыг цаг хугацаанд нь гүйцэтгэх шаардлага тавих, ажлын биелэлтэнд хяналт тавих эрхтэй.

3.3 Төслийн урамшуулалт нь сарынтөг байх бөгөөд Монгол Улсын татварын хуулийн дагуу 10 хувийг хүн амын орлогын албан татварт суутгаж олгох болно.

ДӨРӨВ: Харилцан хүлээх хариуцлага

4.1 Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлын сахилга бат зөрчсөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомж буюу энэхүү Гэрээнд заасан хариуцлага хүлээнэ. Үүнд:

4.1.1 Ажлын сарын хөлсний хэмжээг 20 хүртэл хувиар бууруулах

4.1.2 Гэрээг цуцлах

ТАВ:Бусад

5.1 Гэрээний хугацааг Гэрээний үүргийн биелэлтийг үндэслэн сунгаж болно.

5.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг 2 тал бичгээр гаргаж хэлэлцэнэ

5.3 Гэрээний хоёр хувь адил хүчинтэй

5.4 Талууд Гэрээнд заагдсан үүргийн биелэлттэй холбогдон гарсан аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэх бөгөөд эс тохиролцвол шүүхээр шийдвэрлүүлнэ.

А талыг төлөөлж :

.....

Төслийн багийн ахлагч

Б талыг төлөөлж:

.....

